

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР**

Огноо: 2020.01.20

**БАТЛАВ.**

ХХҮЕГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАДРАХБАЯР

**БНСУ-Д ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАХ ХҮСЭЛТЭЙ ИРГЭДИЙН  
БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН  
БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ПРОГРАМ ХАНГАМЖ БОЛОВСРУУЛАН,  
НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр:**

БНСУ-Д ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАХ  
ХҮСЭЛТЭЙ ИРГЭДИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН  
БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ПРОГРАМ ХАНГАМЖ  
БОЛОВСРУУЛАН, НИЙЛҮҮЛЭХ

**Төслийн дугаар:**

.....

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийн бүртгэлийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулахад шаардагдах програм хангамж боловсруулан, нийлүүлэх –ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 1-р сарын 29-ний өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Өөрийн байр, 201 *тоот гэсэн* хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 01-р сарын 29-ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх **Үгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо,  
Өөрийн байр, 201 тоот  
Утас: 77121285**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]  |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 2 програм хангамж боловсруулсан ажлын туршлагын талаарх мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, актын хамт, жилд нэг удаа байх/;</p> <p>Бусад нэмэлт шаардлага;</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээ /Хуулбар, нотариатаар баталгаажуулсан/</li> <li>2. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт</li> <li>3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт</li> <li>4. Харилцагч бүх банкны тодорхойлолт;</li> <li>5. Бараа нийлүүлэлтийн хуваарь. /Маягтын дагуу/</li> <li>6. Бараа нийлүүлэлтийн үнийн хуваарь. /Маягтын дагуу/</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Өөрийн байр, 207 тоот, Утас: 77121285</b></p> <p>Огноо: <i>2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 00 минут</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: : <b>Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Өөрийн байр, 201 тоот, Утас: 77121285</b></p> <p>Огноо: <i>2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 30 минут</i></p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Байгууллагын албан хүсэлт</li> <li>2. Байгууллагын танилцуулга</li> </ol>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй</b></p>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Барааны тодорхойлолт:

БНСУ-д ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАХ ХҮСЭЛТЭЙ ИРГЭДИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ПРОГРАМ ХАНГАМЖ БОЛОВСРУУЛАН, НИЙЛҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### НЭГ. ЗОРИЛГО

БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийн бүртгэлийн үйл ажиллагааг түргэн шуурхай, нэгдсэн байдлаар зохион байгуулахад шаардагдах програм хангамжийг хөгжүүлэх нь энэхүү үйл ажиллагааны үндсэн зорилго болно.

### ХОЁР. ҮНДЭСЛЭЛ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь Монгол Улсын Засгийн газар /ХНХЯ/, БНСУ-ын Засгийн газар /Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам/ хооронд байгуулсан Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу БНСУ-д ажилтан илгээх болон хүлээн авах тухай Харилцан ойлголцлын “САНАМЖ БИЧИГ”-ийн хүрээнд БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүч илгээх ажлыг шат дарааллын дагуу тасралтгүй явуулдаг. Энэ ажлын хүрээнд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, зөв зохистой, ил тод хүргэх зорилго дор иргэдийг цахим хэлбэрээр бүртгэхэд шаардлагатай програм хангамжийг боловсруулах нэн чухал шаардлагатай байна.

### ГУРАВ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Нээлттэй open source ашигласан байна.

#### А. Системийн аюулгүй байдлын хамгаалалтын түвшин

1. SSL сертификат ашиглах;
2. Команд ллайн халдлагаас хамгаалах;
3. Нэг төхөөрөмжөөс нэгээс олон удаа нэвтрэх боломжгүй байх, эдгээр болон бусад системийн гаднын халдлагаас хамгаалсан байх;
4. Dynamic url хаяглалттай байх
5. Бүх төрлийн платформ дээр ашиглах боломжтой байх
6. Гаднын халдлагаас хамгаалах

- a. SQL injection
- b. Keylogger injection
- c. Cookie theft
- d. Cross-site scripting
- e. Denial-of-Service
- f. D-Dos түвшиний хамгаалалт

## **Б. Ерөнхий тестийн модуль**

1. Энэхүү модуль нь БНСУ –ын шалгалтанд бүртгүүлэх хүсэлттэй иргэдээс онлайнаар мэдлэг шалгах тест авах бөгөөд тухайн тестийг иргэн алдсан тохиолдолд шалгалтанд дахин бүртгүүлэх боломжгүй болно.
2. Уг тестийг системийн удирдлагаас админ үүсгэх боломжтой боломжтой байх.
3. Системд бүртгэлтэй тестээс шалгалт өгч буй иргэнд автоматаар үүсгэдэг байх ба хүн бүрт харилцан адилгүй байх. Тухайн иргэнээс авсан шалгалт болон асуултыг систем өөр дээрээ бүртгэлжүүлж авдаг байх.
4. Тестийг системийн удирдлагаас тестийг бөглөх хугацааг зааж өгөх боломжтой байх.

## **В. Бүртгэлийн модуль**

*Шалгалт эхлэхээс өмнө админ удирдлагаас бүртгэлийн тоо хязгаарыг аймаг, дүүргээр ялгаварлан тоон хязгаар зааж өгдөг байх ба шалгалтанд тэнцсэн иргэдийн тоо тухайн тоон хязгаараас хэтрэхгүй бүртгэдэг байх. Энэ тоон хязгаар нь банканд төлбөр төлсөн иргэдийн тоотой заавал тэнцэж баталгаажуулдаг байх. Удирдлага тохиргооноос шалгалтанд тэнцсэн иргэдэд олгох тоон форматын загварыг оруулах боломжтой байх.*

1. Урьдчилсан шалгалт  
Солонгос хэлний түвшинг тогтоох тестийг бөглөнө. Энэ тестийг нэг удаа бөглөх боломжтойгоор бэлтгэх. Тестэд тэнцээгүй иргэн бүртгүүлэх боломжгүй болно;
2. Овог нэр  
Латин, дэвшүүлсэн үсгээр бичих, гадаад паспорт эсвэл цахим үнэмлэхийн латин овог нэртэй ижил байх;
3. Хүйс  
Эр, эм гэж сонгохоор бэлтгэх;

4. Цээж зураг  
Шаардлага: 100-300 пиксел, зөвхөн jpg форматтай байх, файлын хэмжээ 15кв хүртэл байх;  
*Хэрэв хэрэглэгчийн оруулж буй зураг чанрын шаардлага хангахгүй тохиолдолд иргэний бүртгэлийг хийх боломжгүй болж админд мэдэгддэг байх*
5. Төрсөн, он, сар, өдөр  
Жишээ нь: ЖЖЖЖ-СС-ӨӨ;
6. Гадаад паспорт эсвэл регистрийн дугаар  
Регистрийн эхний үсгийг латин, дэвшүүлсэн үсгээр бичих, гадаад паспорт эсвэл цахим үнэмлэхийн латин овог нэртэй ижил байх. Тухайн регистрийн дугаар болон гадаад паспортын дугаарын формат зөв эсэхийг шалгаж буруу тохиолдолд бүртгэх боломжгүй байх.
7. Улс  
Зөвхөн Монгол Улс гэдгээр тавих;
8. Ажиллахыг хүсч буй аж үйлдвэрийн дэд салбар  
Сонголттойгоор хийх: Холбох, угсрах, хэмжих;
9. Утасны дугаар. *Зөвхөн Монгол улсад бүртгэлтэй гар утасны дугаар авах боломжтой байх*  
Жишээ нь: 99999999;
10. Гадаад паспорт эсвэл цахим үнэмлэхийн хуулбарыг файлаар хавсаргах  
Шаардлага: 600 пиксел, зөвхөн jpg форматтай байх, файлын хэмжээ 100кв хүртэл байх.  
*Хэрэв хэрэглэгчийн оруулж буй зураг чанрын шаардлага хангахгүй тохиолдолд иргэний бүртгэлийг хийх боломжгүй болж админд мэдэгддэг байх*
11. 5 жилээс дээш хугацаанд солонгос улсад хөдөлмөр эрхэлсэн эсэх  
Сонголттойгоор бэлтгэх: 5 жилээс дээш хугацаанд хөдөлмөр эрхэлсэн/бүртгүүлэх боломжгүй/, 5 жилээс доош хугацаанд хөдөлмөр эрхэлсэн;
12. Анкет бүрэн зөв бөглөгдсөн тохиолдолд шалгалтын хураамжийг цахим хэлбэрээр баталгаажуулж бүртгэлийн хуудсыг хэвлэх, тухайн иргэний гар утас, цахим шууданд мэдээллийг хүргэх боломжтойгоор бэлтгэх. Хэрэв



иргний цахим төлбөр баталгаажуулах тохиолдолд иргэн идвэхгүй төлөвт шилжиж ордог байх төлбөр баталгаажих хүртэл.

13. Бүртгэл амжилттай болсон тохиолдолд иргэн өөрийн бүртгэлийн анкет болон системээс автоматаар өгсөн форматын дагуу шалгалтын дугаар олгодог байх ба тухайн маягыг иргэн PDF –ээр татаж авах болон шууд хэвлэх боломжтой байх.

14. Бүх бүртгэл амжилттай болсон тохиолдолд шалгалтанд бүртгүүлсэн иргэнд тухайн иргэний шалгалтанд бүртгүүлсэн дугаар болон овог, нэрийг баталгаажуулж бүртгүүлсэн утасны дугаарт SMS илгээдэг байх.

#### **Г. Шалгалтын хуваарь харах модуль**

1. Бүртгэлийн дугаарыг оруулан өөрийн шалгалтын хуваарь, байршлыг мэдэх боломжтойгоор бэлтгэх, шалгалт/схттш, ур чадварын шалгалт/ өгөхөөс 3 хоногийн өмнө бүртгэлтэй утасны дугаарт сануулах мессеж систем автоматаар илгээдэг байх;

#### **Д. Ажлын санал, цахим, визийн зөвшөөрлийн модуль**

1. Жагсаалт хэлбэрээр үүсдэг байх /жагсаалт өдөр өдрөөр гүйлгэн харах боломжтой байх/, жагсаалтыг тодорхой форматтай файлыг мэдээллийн санд нэмдэг байх;
2. СПАС програмаас авсан мэдээллийг өмнөх бүртгэлтэй тулган ажлын санал, цахим визийн зөвшөөрөл ирсэн тохиолдолд бүртгэлтэй иргэнд мессеж илгээдэг байх;

#### **Е. Хөрвүүлэлтийн модуль**

1. Шалгалтад тэнцсэн иргэдийн мэдээлэл болон зургийг xml, csv, json форматад хүрвүүлэн нэгтгэн татаж болдог байхаар бэлтгэх;

#### **Ё. Ерөнхий удирдлагын модуль**

1. Иргэдэд зориулсан мэдээ мэдээлэл оруулах хэсэгтэй байх
2. Энэхүү модулийг ашиглан системд шаардлагатай мэдээ мэдээллийг оруулж өгөдөг байх
3. Шалгалт эхлэх он сар өдөр болон системийн ажиллагааг бүрэн хянах боломжтой байх.
4. Яг одоо хэдэн хүн шалгалтанд бүртгүүлсэн, хэдэн хүн тэцсэн, хэдэн цагт хэр хандалттай байгааг харуулсан тоон статистик гаргадаг байх.
5. Банкинд хэдэн хүн яг одоо төлбөр төлсөн байгаа тоон мэдээллийг авдаг байх.

2. **Стандарт:** Шаардлагагүй

3. **Баглаа, боодол:** Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын серверт суурилуулна.

4. **Бараа хүргэх газар:**

Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Өөрийн байр, 305 тоот,  
Утас: 77121288

5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын төв серверт суурилуулна. Програм хангамжийг туршин нэвтрүүлэх, тестлэх ажлыг зохион байгуулж, хэрэглэгчийн хандалтыг тодорхойлон ачааллыг тооцож, шаардлагатай тохируулга хийсэн байна.  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх баримт бичгүүд: <ul style="list-style-type: none"><li>1) БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийн бүртгэлийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулахад шаардагдах програм хангамж, 1 програм хангамж, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) Програм хангамж суурилуулсан ажлын акт, холбогдох баримт бичиг</li><li>3) Баталгаат засварыг 1 жилийн хугацаанд үзүүлнэ гэсэн байгууллагын албан бичиг</li><li>4) Програм хангамжийн эх кодыг агуулсан CD, DVD;</li></ul> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.<br><br>1 жил байна.   |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний үнийн дүнгийн <b>30</b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup></b>                  | 9.1. Алданги оногдуулах хувь: <b>0,1</b><br><br>Алдангийн нийт дүн: <b>1 хувь</b>   |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*